

50



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 65

Номгон

Г Т
Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох санал
хэлэлцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2. дахь заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Өлзийт сумын нутаг Харганы худаг нэртэй 25.20 гектар талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох саналыг дэмжсүгэй.

2. Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг олгож, олгосон тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг мэргэжлийн байгууллагад хүргүүлж, кадастр, зураг зүйн системд бүртгүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0121116